

БАТЛАВ
УЛААНБААТАР ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ ТӨРИЙН
ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРАЛ
Д.БАЯРСАЙХАН

ТЕХНИКИЙН НӨХЦӨЛ

Дугаар 15/05815/19

2019 оны 12 сарын 08 дөр

Улаанбаатар хот

Нэг. Ерөнхий мэдээлэл:

1.1	Хүсэлтийн дугаар:	19-54-001005
1.2	Хэрэглэгчийн нэр, регистр:	СҮХБААТАР ДҮҮРГИЙН АРВАН ЗУРГААДУГААР ЦЭЦЭРЛЭГ Төрийн байгууллага, РД: 9086919
1.3	Хэрэглэгчийн байршил:	Улаанбаатар Сүхбаатар 1-р хороо, С,зоригийн гудамж 1-р эмнэлэгийн баруун талд өөрийн байр
1.4	Ажил үйлчилгээний зориулалт:	Цэцэрлэг
1.5	Техникийн нөхцөл олгох үндэслэл:	1) Газар эзэмших эрхийн 2004-02-16-ны 0002545 тоот гэрчилгээ. 2) Архитектур төлөвлөлтийн 2016 оны 2016/10-08 тоот даалгавар, барилгажих талбайн схем зураг
1.6	Техникийн нөхцөлийн ангилал:	Шинэ холболт
1.7	Тооцооны бүрэн чадал:	150 кВА /Нэг зуун тавь/ (тоогоор) (үсгээр)

Хоёр. Холболтын цэг:

2.1	110/10/6 кВ-ын Өмнөд дэд станц, ШУТО РП-с 6 кВ-ын ГЯЯ фидерийн ХТП-136 дэд өртөөний 0.4 кВ талын I ба II секцэнд шинээр рубильник бүхий групп тоноглож кабель шугам татаж тэжээх.
-----	---

Гурав. Тоолуур, хэмжих хэрэгсэл:

3.1	Өөрийн байрны 0.4 кВ-ын щитэнд ачаалалд тохирсон дифференциал автомат, хамгаалан таслах төхөөрөмж, /УЗО/, DLMS протоколыг дэмждэг 3 фазын баталгаат, бүрэн электрон 5 А тоолуур, гүйдлийн трансформатор суурилуулах.
-----	--

Дөрөв. Тусгай заалтууд:

4.1	Щитний газардуулга болон шугам тоноглолын хэмжилт, туршилтыг норм, дүрмийн дагуу хийлгэн холбогдох газраар шалгуулж протокол авсан байх.
4.2	Гадны эзэмшлийн шугам тоноглолоос холбогдох тохиолдолд тус эзэмшигчээс зөвшөөрөл авах.
4.3	Эрчим хүчний сайдын 2019 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн 276 тоот тушаалын дагуу энэхүү техникийн нөхцөлөөр 2020 оны 03 сарын 01-нээс хойш сүлжээнд холбогдохыг анхаарна уу.

Тав. Дор дурдсан техникийн даалгавар, хууль дүрмийг мөрдөх:






5.1	Шугамын "Ажлын зураг төсөл"-ийг тухайн нутаг дэвсгэрийн ерөнхий төлөвлөгөө хариуцсан нэгж болон бусад шаардлагатай байгууллагуудтай зөвшилцөн,
-----	--

	мэдээллийн санд оруулсан байх, схем холболт, хүчин чадлыг тус компаниар хянуулах.
5.2	Энэхүү техникийн нөхцөлийн дагуу тавигдах шугам, тоноглолууд нь Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ төрийн өмчит хувьцаат компанийн баталсан "Техникийн шаардлагын тодорхойлолт"- ыг хангасан байх шаардлагатай. Техникийн шаардлагын тодорхойлолтыг www.tog.mn хаягаар орж хууль, дүрэм цонхноос үзэх.
5.3	Хүсэлт гаргагч нь хэрэглэх чадалдаа тохируулж чадлын хязгаарлагчийг суурилуулах. Техникийн тодорхойлолтыг Техникийн бодлого зохицуулалтын хэлтсээс авах.
5.4	Цахилгаан шугам сүлжээнд холбогдох явцад дайрч гарах зам талбай, бут сөөгийг сэргээн засварлах.
5.5	Засгийн газрын 2001 оны 263 тоот тогтоолоор батлагдсан "Цахилгаан эрчим хүч хэрэглэх дүрэм"-ийн заалтуудыг мөрдлөг болгох.
5.6	"Эрчим хүчний тухай" хуулийн 29.1.9, 30.1.10-ийн дагуу өөрийн тоноглолоос тус компанийн зөвшөөрлөөр шинээр хэрэглэгч нэмж холбуулах.
5.7	"Эрчим хүчний тухай" хуулийн 33 дугаар зүйлд заасны дагуу шугам сүлжээний хамгаалалтын зурвас дотор гэр, орон сууц, барилга байгууламж барих, шугам сүлжээ өмчлөгч, эзэмшигчийн зөвшөөрснөөс бусад үйл ажиллагаа явуулахыг хориглоно.
5.8	Угсралтын ажлын явцад тус компанийн харьяа түгээх төвөөр хяналт тавиулж, холбогдох баримтыг бүрдүүлсэн байх.
5.9	Цахилгаан угсралтын ажлыг тусгай зөвшөөрөлтэй эрх бүхий байгууллагаар Аюулгүй ажиллагааны дүрэм, Техник ашиглалтын дүрэм, Цахилгаан байгууламжийн дүрмийн дагуу гүйцэтгүүлэх.
5.10	Цахилгаан эрчим хүчний тооцоог Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ төрийн өмчит хувьцаат компанийн харьяа хэрэглэгчдэд үйлчлэх төвтэй хийх.

Зургаа. Бусад:

6.1	Энэхүү техникийн нөхцөлийн дагуу холболтыг 1 жилийн хугацаанд хийж гүйцэтгэх бөгөөд энэ хугацаанд цахилгаан сүлжээнд холбогдоогүй тохиолдолд шинээр техникийн нөхцөл авна.
-----	--

Комиссын гишүүд:

 Л.Ганзориг
 Б.Азаяа
 Т.Мөнхболд
 А.Зоригт
 Г.Наранбаяр

Боловсруулсан:



ӨНДӨР ХУРДНЫ

БАТЛАВ

МЭДЭЭЛЭЛ ХОЛБООНЫ СҮЛЖЭЭ

ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Ч.ЗОЛБАЯР

2019 оны 10 сарын 24

ТЕХНИКИЙН НӨХЦӨЛ

Дугаар: ТН-В778/2019

2019/10/23

Захиалагч
байгууллага: СҮХБААТАР ДҮҮРЭГ ЗАСАГ ДАРГЫН ТАМГИЙН ГАЗАР

Хэрэглэгчийн нэр: М.БЯМБАСҮРЭН

Харилцах утас: 70070109

1. Байршил: СБД-н 1-р хорооны нутаг дэвсгэрт.

2. Зориулалт: Цэцэрлэгийн барилга

3. Холбооны хэрэгцээ: /урьдчилсан тооцоогоор/
Телефон тоо (ширхэгээр) 10 ш

4. **Техникийн онцгой нөхцөл:** Харилцаа Холбооны Зохицуулах хорооноос олгогдсон үндсэн сүлжээ байгуулах бүрэн эрхийнхээ дагуу холбоожуулах техникийн нөхцлийг зөвхөн МХС ХХК олгох бөгөөд техникийн нөхцөлгүйгээр холбооны бүх төрлийн үйлчилгээний зориулалттайгаар кабель татах болон шилжүүлсэн тохиолдолд уг барилга объектыг техникийн болон улсын комиссоор хүлээн авахгүй болно.

5. Техникийн үндсэн нөхцөл

- 5.1. MSAN 249-ний хүрээний S-C 49-1-1 худгаас барилга хүртэл 110 мм-н 2 яндантай сувагчлал хийх ба шинээр хийх сувагчлалыг 1,0-1,2 метрийн гүнд суурилуулна.
- 5.2. Сувагчлал хооронд худаг суурилуулах зай хэмжээг 120 метрээс хэтрэхгүй байхаар тооцох ба эргэлт болон барилгын оролтонд зайлшгүй стандартын худаг суурилуулна
- 5.3. MSAN 249-ний 0-р зуутын 1-р аравтыг одоо байгаа сувагчлал болон шинээр хийсэн сувагчлалаар татан барилгад оруулж төгсгөлийн төхөөрөмжид холбоно.
- 5.4. Харилцаа Холбооны Зохицуулах Хорооноос олгосон холбооны кабель шугамын угсралт хийх тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжээр гүйцэтгүүлэх шаардлагатай.

6. Зураг төсөвт зайлшгүй тусгах шаардлагатай технологийн онцгой нөхцлүүд:

- 6.1. Шинээр хийгдэх кабель, шугамын угсралтын ажлын зураг төсвийг зохиохдоо Монгол улсын стандарт MNS 5276:2003, MNS 5279:2003, MNS 5280:2003, MNS 5277:2003 тоот ерөнхий шаардлагууд болон ДБХ-ийн сайдын 1995 оны 127-р тушаалаар батлагдсан зааврыг баримтлан гүйцэтгэх.
- 6.2. Хэрэглэгчийн шугамын угсралтын ажил барилгын зураг төсөвт байхгүй болон хийгдээгүй бол захиалагчид мэдэгдэж төсөв зурагт оруулах.
- 6.3. Кабелийн хуваарилах хайрцагны байрлалыг хэрэглэгчийн шугамын нягтралын цэгт болон техник ашиглалтын шаардлага хангахуйц байдлаар сонгон суурилуулахаар технологийн норм хэмжээг зааж оруулах.

7. Угсралтын ажлын үед тавигдах нөхцөл:

- 7.1. Угсралтын ажил эхлэхээс өмнө зураг төсөв техникийн нөхцлийн дагуу хийгдсэн эсэхийг Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-ны УБ Хотын сүлжээний газрын Бүртгэл төлөвлөлтийн тасгаар (Утас: 70112399) хянуулан баталгааг авсан байх.
- 7.2. Газар шорооны ажил гүйцэтгэхдээ харъяалагдах тухайн тасгийн ахлах инженер болон инженерээр шалгуулан далд ажлын акт үйлдэж хүлээн авах ажлын актанд хавсаргах.
- 7.3. Кабель шугамын угсралт болон газар шорооны ажлыг эхлэхдээ УБ Хотын сүлжээний газрын ерөнхий инженерээс албан ёсны мэдэгдлийг авч тухайн харъяалагдах тасгийн ахлах инженерийн хяналтан дор гүйцэтгэнэ.

- 7.4. Шинээр татсан кабель болон кробканд тэмдэглэгээг бүрэн хийсэн байх.
- 7.5. Угсралтын ажлын явцад захиалагч ашиглалтын байгууллагатай хамтарч хяналт тавьж угсралтын технологийн шаардлагыг бүрэн хангуулсан байх.
- 7.6. Хэрэглэгч холбох нөхцлийг бүрдүүлэхийн тулд барилгын дотор монтажийн угсралтыг Монгол улсын стандарт MNS 5471:2005 ерөнхий шаардлагын дагуу хийгдсэн, техникийн актны хамт гадна холбооны угсралтын ажлыг хүлээж авна. Шинээр хийсэн сувагчлалын трассыг Нийслэлийн мэдээллийн санд оруулсан тодорхойлолт бичиг болон CD-г техникийн актны хамт УБ Хотын сүлжээний газарт хүлээлгэн өгнө.

8. Захиалагчид ашиглалтын үед тавигдах шаардлага:

Шинээр хийгдсэн холбооны худаг сув агчлал болон кабель шугам нь хотын телефоны кабель шугамын сүлжээнд холбогдох тул:


- 8.1. Танай эдэлбэр газарт суурилуулагдсан холбооны сувагчлал болон кабелийн гадны механик гэмтэлээс хамгаална.
- 8.2. Уг сувагчлалын трассыг цааш нь үргэлжлүүлэх болон шинээр кабель татах боломжийг хангах.
- 8.3. Худаг сувагчлалд техникийн ашиглалтыг хоногийн ямар ч үед ажил үйлчилгээг шуурхай гүйцэтгэх боломжоор бүрэн хангах.

9. Техникийн нөхцлийг СҮХБААТАР ДҮҮРЭГ ЗАСАГ ДАРГЫН ТАМГИЙН ГАЗАР-н Төлөвлөлт, гүйцэтгэлийн хяналт, шинжилгээний хэлтсийн даргын 2019 оны 10-р сарын 15-ний өдрийн 6/2561 тоот албан бичгийг үндэслэн олгов.


10. Угсралтын ажил дууссаны дараа хэмжилт шалгалт хийлгэж тогтоосон журмын дагуу УБ Хотын сүлжээний газарт техникийн актаар хүлээлгэн өгсний дараа сүлжээнд холбох зөвшөөрлийг авна.

11. ЭНЭХҮҮ ТЕХНИКИЙН НӨХЦӨЛ НЬ ОЛГОСОН ӨДРӨӨС ХОЙШ 1 ЖИЛИЙН ХУГАЦААНД ХҮЧИНТЭЙ.


Техникийн нөхцөлтэй танилцсан:
УБХСГ-ын Дарга


Н.МАНДАХБААТАР

Техникийн нөхцлийг хянасан:
УБХСГ-ын Ерөнхий инженер


Н.НАРАНБААТАР

Боловсруулсан :
УБХСГ-ын БТТ-ийн ахлах инженер


Д.БАЛМАА

БАТЛАВ.УБДС ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



УБДС ТӨХК-ийн Техникийн нөхцөл олгох комиссын 2020 оны 4-р сарын 3-ний өдрийн цахим хурлын шийдвэрээр зөвшөөрөв.

Г. БАЯРСАЙХАН

ТЕХНИКИЙН НӨХЦӨЛ № 043/2020

1. **Хэрэглэгчийн нэр:** Сүхбаатар дүүргийн Засаг даргын Тамгын газар /16-р цэцэрлэгийн өргөтгөл/
2. **Барилгын мэдээлэл:** Цэцэрлэгийн барилга
3. **Хэрэглэгчийн байршил:** Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Улсын 1-р төв эмнэлгийн баруун талд
4. **Дулааны хэрэглээ:**

Нийт :	0.13 Гкал/цаг
А.Халаалт	0.10 Гкал/цаг
Б.Хэрэгцээний халуун ус	0.03 Гкал/цаг
В.Салхилуулга	0.00 Гкал/цаг
5. **Холболтын цэг:** 2а магистраль ДХ212 худгаас холболттой салаа шугамаас тусдаа салаа шугам татаж холбогдох
Шугамын даралт, температурын утга:

А. Холболтын цэг дээр байх түрэлт	10 м
Б. Шугамын статик даралт	40 м.у.б
В. Буцах шугамын даралт	5.5 ата
Г. Гадна агаарын тооцоот температур	-39 °С
Д. Температурын график	135/70 °С
6. **Мөрдөж хэрэгжүүлэх хууль, дүрэм журам**
 - 6.1 Эрчим хүчний тухай хууль
 - 6.2 Засгийн газрын 2001 оны 12-р сарын 5-ны өдрийн 263 тоот тогтоолоор батлагдсан "Дулааны эрчим хүч хэрэглэх дүрэм"
 - 6.3 Эрчим Хүчний Зохицуулах Хорооны 2018 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн 290 дүгээр тогтоолоор батлагдсан Дулаан дамжуулах, түгээх сүлжээний "Холболтын журам"
 - 6.4 Эрчим хүчний тухай хуулийн 14-р зүйлийн 14.4-т заасны дагуу Эрчим хүч дамжуулах шугам, дэд станц нь төрийн өмчлөлд байна.
7. **Зураг төсөл, төсөв боловсруулахад тавигдах шаардлага :**
 - 7.1 **Зураг төслийн үндсэн шаардлага**
 - 7.1.1 "Эрчим хүчний тухай хууль"-ийн 33 дугаар зүйл, "Эрчим хүчний шугам сүлжээг хамгаалах дүрэм"-ийн 1.3 дах заалтыг мөрдөж дулааны төв шугам, салаа болон салбар шугамаас хамгаалалтын зурвасын зайг хангаж барилгыг төлөвлөх. Шугамын хамгаалалтын зурваст тохижилт, зам талбай, зогсоол, бусад байгууламж төлөвлөхгүй байх.
 - 7.1.2 Шугамын трасс сонголт, холболтыг хийхдээ салаа шугам эзэмшигч, шугамын трасс дагуух газар эзэмшигчтэй урьдчилан зөвшөөрөлцөх, бусдын эзэмшил газар шугамын трассыг сонгохгүй байх.
 - 7.1.3 Архитектур төлөвлөлтийн даалгавар, эскиз зургийг үндэслэн зураг төслийг хянана.
 - 7.1.4 Төлөвлөж буй барилгын дулааны ачааллыг техникийн нөхцлийн хэмжээнээс хэтрүүлэхгүй байх, өргөтгөлийн барилга нэмж төлөвлөхгүй байх.

7.2 Дор дурдсан техникийн даалгаврын дагуу зураг төслийг хийх

- 7.2.1 Төлөвлөж буй барилгад төвлөрсөн дулаан хангамжийн техник ашиглалтын шаардлага хангасан халаалтын цогц төхөөрөмж суурилуулах.
- 7.2.2 Техникийн нөхцөлийн хүчинтэй хугацаанд багтаан дулаан хангамжид холбогдох
- 7.2.3 Барилгын дотор халаалтын системд балансын хаалт, термостат хаалт суурилуулах
- 7.2.4 Стандартын шаардлага хангасан дулааны тоолуур суурилуулах.
- 7.2.5 Гадна дулааны шугам болон узелийн тоноглолыг дулааны алдагдлын норм нормативд нийцсэн материалаар техник ашиглалтын шаардлагын дагуу дулаалахаар зураг төсөвт тусгах.
- 7.2.6 Дулааны шугам сүлжээ авто зам доогуур огтлох нөхцөлд нэвтрэх сувагтай байхаар төлөвлөж зураг төсөвт тусгах.
- 7.2.7 Дулааны шугамыг барихдаа трассын дагуух тохижилт, нөхөн сэргээх ажлын зардал болон гадна дулаан хангамжийн систем, узель ба дотор системийн угаалт, шахалтын туршилт хийх зардлыг төсөвт тусгах.
- 7.2.8 Улаанбаатар хотын ерөнхий архитектор бөгөөд Ерөнхий төлөвлөгөөний газрын даргын 2016 оны 4 сарын 18-ний өдрийн 2016/10-08 дугаартай архитектур төлөвлөлтийн даалгавар, батлагдсан эскиз зургийг үндэслэв.

8. Техникийн нөхцөлд тавигдах нэмэлт шаардлага:

- 8.1 "Эрчим хүчний тухай хууль"-ийн 30 дугаар зүйлийн 30.1.10; 29 дүгээр зүйлийн 29.1.9дэх заалтыг мөрдөж өөрийн эзэмшлийн шугам, тоног төхөөрөмжөөс бусад хэрэглэгчийг холбуулах.
- 8.2 Дулааны шугам, тоноглол угсрах, хянах хэмжих хэрэгсэл суурилуулах, дулаалга хийхдээ Техник ашиглалт, аюулгүй ажиллагааны дүрмийг чанд мөрдөж ажиллах.
- 8.3 Төлөвлөж буй барилгын дулааны ачааллыг техникийн нөхцөлийн хэмжээнээс хэтрүүлэхгүй байх, өргөтгөлийн барилга нэмж төлөвлөхгүй байх

9. Техникийн нөхцөл олгох шалтгаан

Техникийн нөхцөлийн my.dulaan.mn цахим системд ирүүлсэн материалын дагуу хурлыг цахимаар хийхэд нийт гишүүдийн олонхийн саналаар дэмжигдэв.

10. Техникийн нөхцөлийн хүчинтэй хугацаа

Энэхүү техникийн нөхцөл олгосноос хойш 2 жилийн хугацаанд хүчинтэй байна.

ЗӨВШӨӨРСӨН.

ТЕХНИКИЙН НӨХЦӨЛ ОЛГОХ КОМИССЫН ДАРГА,
ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР

ХЯНАСАН:

ТХХ-ИЙН ДАРГА

БОЛОВСРУУЛСАН:


ТХХ-ИЙН ИНЖЕНЕР



Б.БАТБАЯР

Б.ХҮРЭЛМӨНХ

Б.ОЧБАЯР



БАТЛАВ
 УС СУВГИЙН УДИРДАХ ГАЗРЫН
 ДАРГА **Ц.ТӨРХҮҮ**

УСУГ-ын Техникийн нөхцөл олгох комиссын
 2019 оны 12-р сарын 25-ны өдрийн хурлын
 890 тоот протоколыг үндэслэн зөвшөөрөв.

ТЕХНИКИЙН НӨХЦӨЛ № 890 \ 19






1	Барилга байгууламжийн нэр, зориулалт, байршил	СБД-ийн ЗДТГазар, 16-р цэцэрлэг, 200 хүүхдийн цэцэрлэгийн 2 давхар барилга, СБД 1-р хороо, одоо байгаа 16-р цэцэрлэгийн баруун талд
2	Нийт усны хэрэглээ:	Цэвэр усны - 12,5 м ³ /хон Галын усны - 2,5 л/с Бохир усны - 12,5 м ³ /хон
3	Цэвэр усны холболт хийх цэгийн байршил, шугамын диаметр	Төвийн цэвэр усны шугамнаас холболттой хэрэглэгчдийн дундын Ф100 мм-ийн шугамын худагнаас холбох, ажлын зургийн явцад зөвшилцөх
4	Бохир усны холболт хийх цэгийн байршил, шугамын диаметр	Төвийн бохир усны Ф600 мм-ийн шугамын худагт холбох, ажлын зургийн явцад зөвшилцөх
5	Нэмэлт нөхцөл	Бусад шаардлага: <ul style="list-style-type: none"> ➢ Ус хангамж, ариутгах татуургын системийн угаалга, шахалт, туршилт тохируулгын ажлын зардлыг зураг төсөвт тусгах. ➢ Барилгын гадна цэвэр, бохир усны шугам сүлжээний холбох цэгийг өөрчлөх тохиолдолд хүсэлт тавьж хянуулан, хангагч байгууллагын зөвшөөрлөөр гүйцэтгэнэ. ➢ Холбогдох Хууль, БНБД, стандартыг мөрдөх ➢ Гадна шугамын ажлын зургийг ХБХГ-тай зөвшилцөх
6	Тавигдах шаардлага	<ol style="list-style-type: none"> 1.Барилгыг "Хот суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай" хуулийн дагуу цэвэр усны шугамын тэнхлэгээс 5м, бохир усны шугамын тэнхлэгээс 6 метр зайд барих 2.Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай" хуулийн 15.1.10-ын дагуу хангагч нь хэрэглэгчийн шугамнаас дамжуулан шинээр хэрэглэгч холбох техникийн нөхцөл олгосон тохиолдолд батлагдсан ажлын зураг, төслийн дагуу дараагийн хэрэглэгчийг холбуулах. 3.Борооны ус зайлуулах шугам сүлжээг тусад нь төлөвлөх, борооны усыг бохир усны шугаманд нийлүүлэхгүй байх. 4.Цэвэр, бохир усны шугамын угсралт, шахалт туршилт, холболтын ажлын явцад ашиглалтын байгууллагын хяналтын инженерийг байлцуулж ил, далд ажлын акт хөтөлнө. 5.Төвийн болон хэрэглэгчийн цэвэр, бохир усны худаг, шугам сүлжээн дээр болон хамгаалалтын бүсэд зам талбай, авто зогсоол, барилгын довжоо, хүүхдийн тоглоомын талбай зэргийг төлөвлөсөн тохиолдолд засвар үйлчилгээ хийх боломжыг бүрдүүлэх, засварын дараахь нөхөн сэргээлтийн ажлыг өөрсдөө хариуцах 6.Техникийн нөхцлийн хүчинтэй хугацаа 2 жил.
7	Объект барих дээд газрын шийдвэр:	<ul style="list-style-type: none"> ➢ Газар эзэмших эрхийн 0002545 тоот гэрчилгээ ➢ 2016/10-08 тоот архитектур төлөвлөлтийн даалгавар
8	Хэрэглэгчийн нэр, утас:	СБД-ийн ЗДТГазар, Утас: 99486322

890/19 тоот техникийн нөхцлийн схем зураг:



ТАНИХ ТЭМДЭГ

ТОДОРХОЙЛОЛТ

-  Шугам сүлжээнд холбогдох барилга
-  Цэвэр усны шугам
-  Цэвэр усны худаг
-  Бохир усны шугам
-  Бохир усны худаг

1	Төлөвлөж буй цэцэрлэг
2	Одоо байгаа 16-р цэцэрлэг
3	ХХБанк
4	Авто зам, талбай

Ус сувгийн удирдах газрын 802 тоот

Утас: 70157018- 182,

website: <http://usug.ub.gov.mn>

УСУГ-ЫН ТЕХНИКИЙН НӨХЦЛИЙН ИНЖЕНЕР

Ц.ЦЭРЭНДУЛАМ



НИЙСЛЭЛИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗАР
БАРИЛГЫН ЗУРАГ ТӨСЛИЙН ХЯНАЛТЫН БАЙЦААГЧИЙН
ДҮГНЭЛТ

2019 оны 11 сарын 06 өдөр

Дугаар 009/58

Улаанбаатар хот

СҮХБААТАР ДҮҮРГИЙН ЗАСАГ
ДАРГЫН ТАМГЫН ГАЗАРТ

Нэг. Барилга байгууламжийн зураг төслийн мэдээлэл

1. Барилга байгууламжийн байршил: Сүхбаатар дүүргийн 1 дүгээр хороо
2. Архитектур төлөвлөлтийн даалгавар: 2016.04.18-ны МЗХ2016/10-08
3. Зургийн шифр, зураг төслийн компани: НК-2019/31 "Нутагконсалтинг" ХХК.
4. Барилга байгууламжийн зориулалт: 200 Хүүхдийн цэцэрлэгийн барилга
5. Барилгын давхар, талбай, эзэлхүүн: 2 давхар, /зоорьтой/ $V = 3969\text{м}^3$
6. Галд тэсвэршилтийн зэрэг: төлөвлөсөн: II
7. Барилгын үүргийн галын аюулын анги: Ф 1.1
8. Зургийн иж бүрдэл 1 хэсэг.

Хоёр. Дүгнэлт

Монгол Улсын газар эзэмших эрхийн гэрчилгээ №0002545 дугаартай 16-р цэцэрлэгт Сүхбаатар дүүргийн Засаг даргын 2004 оны 01 дугаар сарын 28-ний өдрийн А/30 тоот шийдвэрийг үндэслэн нэгж талбарын 6002/0102 дугаартай 3200 м² газрыг 15 жилийн хугацаатай цэцэрлэгийн зориулалтаар олгосон газарт баригдах барилгын ажлын зурагт хяналт хийхэд:

1. Олон нийтийн барилга /БНБД31-03-03/-ийн 3.9 /А/ Сургуулийн өмнөх насны хүүхдийн барилгын хүчин чадал, давхарын хязгаар, барилгын гал тэсвэршилтийн зэрэг хоорондын хамаарлыг аравдугаар хүснэгтэд заасны дагуу төлөвлөх шаардлагатай.

2. Гал тэсвэршилтийн I-III зэрэглэлийн барилгын гадна ханын гадаргууг шатдаг, тэсвэрлэн шатдаг материалаар өнгөлөхийг зөвшөөрөхгүй. /БНБД 21-01-02/-ийн 2.8, Барилгын гадна ханын дулаалгад галд шатдаггүй материал сонгож төлөвлөх / материалын шинжилгээний дүгнэлтийг хавсаргах/

000329

3. Гадна талд гал унтраах /усаар хангах/ гидрант заавал байхаар тооцож, усаар хангах эх үүсвэрийг заавал байхаар төлөвлөж хийж гүйцэтгэх шаардлагатай /БНБД 40-05-098/.

4. Цэцэрлэг баригдах байршилд барилга хоорондын гал эсэргүүцэх зай хэмжээг /БНБД 30-01-04/-ийн заавал биелүүлэх 4 дүгээр хавсралтын дагуу хийж гүйцэтгэх.

5. Цэцэрлэгийн коридор, өрөө тасалгааны хаалгыг гарах чиглэлд онгойхоор төлөвлөх, 1,2 дугаар давхарт авралтын схем зураглал, тэмдэг тэмдэглэлгээ хийж, барилгын гадна талд нормативын дагуу гал унтраах анхан шатны багаж хэрэгслийг авч ашиглах боломжтой газар байрлуулсан байх. Цахилгааны ерөнхий хуваарилах өрөөнд нүүрсхүчлийн хийгээр ажиллах зөөврийн гал унтраагуур төлөвлөх шаардлагатай.

6. Цэцэрлэгийн барилгыг MNS5420-1:2011 стандартын дагуу төлөвлөх.

Дээрх шаардлагыг биелүүлснээр тус ажлын зураг нь галын аюулгүй байдлын шаардлагыг хангаж байгаа болно. /Ажлын зураг дээр зөвшилцөн засаж, нормын дагуу засвар хийгдсэн зургаар барилга угсралтын ажлыг гүйцэтгэсэн байх шаардлагатай/

Барилга эхлэхээс өмнө зураг төсөлд өөрчлөлт оруулах тохиолдолд Онцгой байдлын байгууллагатай зөвшилцөж шийдвэрлэнэ.

Зөвшөөрсөн сар, өдөр	Зөвшөөрлийн тэмдэг дарсан хуудасны дугаарууд	Нэмэлт тэмдэглэл
2019.11.06	Нүүр хуудас, БА 2,3,4 ЦБУ 2,3,4 ХД-5,6,7	Манай байгууллагаас гаргасан дүгнэлтийн дагуу төлөвлөн хийж гүйцэтгэх шаардлагатай.

БАРИЛГЫН ЗУРАГ ТӨСЛИЙН ХЯНАЛТЫН АХЛАХ БАЙЦААГЧ,
ДЭД ХУРАНДАА



Л.ТЭГШБАЯР

БАТЛАВ.
УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ АРХИТЕКТОР БӨГӨӨД НИЙСЛЭЛИЙН
ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГАЗРЫН ДАРГА: /Ю.ОДБАЯР/

АРХИТЕКТУР ТӨЛӨВЛӨЛТИЙН ДААЛГАВАР

2016 оны 4 сарын 18 өдөр

Дугаар: 2016/10-08

Улаанбаатар хот

1	Газар олголтын захирамжийн дугаар, олгогдсон газрын байршил, хэмжээ ГБЗХ-2016/10 дүгнэлт	Нийслэлийн Засаг даргын 2004 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн 30 дугаар шийдвэртэй, 6002/0102 дугаар нэгж талбартай, Сүхбаатар дүүргийн 01 дүгээр хорооны нутаг дэвсгэрт, цэцэрлэг зориулалтаар олгосон 3200 кв.м газрыг үндэслэв.
2	Барилга байгууламжийн нэр, зориулалт, хүчин чадал	16 дугаар цэцэрлэг, 200 хүүхдийн цэцэрлэг
3	Барилгын хэмжээ /гадна ханаар/	21.0х 21.0 метр тагт, довжоог 1,8 метрээс илүүгүй, рампыг нормоор тооцон төлөвлөх
4	Барилгын төрөл, давхрын тоо	Төмөр бетон каркасан (Цутгамал) ,3 давхар, /1 -зоорьтой /
5	Дагаж мөрдөх ерөнхий төлөвлөгөө, ерөнхий төлөвлөгөөний бүсчлэл	2020 оны ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулах.
6	Эдэлбэр газрын:	3200 кв.м
	- Барилгажих талбай (70 хувиас ихгүй)	441 кв.м
	- Ногоон байгууламж, гадна тохижилт	Барилгын орчны төлөвлөлттэй уялдуулах
	- Авто зогсоол	Аж, ахуйн зориулалттай авто машин зогсоох зогсоол төлөвлөх
	- Бусад /гараж/	Барилгажих талбайн хэмжээнд тохируулан, төлөвлөх
7	Талбайн ерөнхий төлөвлөгөө, тохижилтонд тавигдах шаардлага	Орчинтой уялдуулж ногоон байгууламжийн шийдэл гаргах, барилгын гадна гэрэлтүүлгийг цогцоор шийдэх, хашаа хайс барихгүй байх
8	Архитектур төлөвлөлтийн шаардлага	Барилгын гадна өнгөлгөөнд орчны барилгатай уялдуулан өнгө сонгох, барилгын зураг төслийг хийц архитектур төлөвлөлтийн шийдлийг бүрэн гаргаж боловсруулна.
9	Хот төлөвлөлтийн онцгой нөхцөл	Барилгын талбайн зохион байгуулалтын зургийг хавсаргах. Онцгой байдлын үед гал унтраах, аврах баг бүрэлдэхүүн саадгүй ажиллах боломжтой төлөвлөх.
10	Талбайн өндөржилтөнд тавигдах шаардлага	Гадаргуугийн ус зайлуулах арга хэмжээг орчны барилга, зам талбайтай уялдуулан талбайтай уялдуулан талбайн хэмжээнд иж бүрэн шийдвэрлэх
11	Инженерийн шугам сүлжээнд тавигдах шаардлага	Инженерийн шугам сүлжээний хамгаалалтын зурвас, Норм дүрэм стандартыг баримтлан төлөвлөх /Гадна шугам сүлжээний зураг төслийг мэргэжлийн байгууллагаар хянуулах/
12	Инженерийн бэлтгэл арга хэмжээ (үерийн хамгаалалт, далан, суваг, шуудуу, зайлуулах шугам сүлжээ)	Эдэлбэр газарт газрын зураглалын тодруулалт хийлгэх, газар доорхи болон дээрхи шугам сүжээг тодруулсаны үндсэн дээр зураг төслийн боловсруулах
13	Барилгажилтын улаан шугам	Магадлал хийлгэсэн ажлын зургийн дагуу барилгын тэг тэнхлэг тавиулж, барилгын ажлыг эхлүүлэх
14	Захиалагчийн нэр, хаяг, утас	СБДүүргийн ЗДТГазар Мэргэжилтэн Б.Бат-Эрдэнэ 80000858

Анхааруулга:

1. Барилга барих явцад хүрээлэн буй орчны байгалийн тогтоц, өмнө хийгдсэн тохижилт, зам талбай, ногоон байгууламжийг хамгаалах ба хэрэв хөндвөл нөхөн сэргээх.
2. Өндөр барилгын бүсчлэлд талбайн хэмжээнд микросейсмикийн үнэлгээ гаргуулах, цогцолбор барилгын инженерийн хангамж, шугам сүлжээ, дэд бүтцийн техникийн нэгдсэн шийдлийг шийдвэрлэх.
3. Хуучин барилга, байгууламжийг зайлшгүй буулгах, зөөх, засварлах, шаардлагатай болэнэ тухай эрх бүхий байгууллагын албан ёсны техникийн дүгнэлт (акт), шийдвэрийг архитектур төлөвлөлтийн даалгаварт хавсаргах.
4. Барилга байгууламжийн зураг төслийг боловсруулахдаа АТД-т заасан нэр, зориулалт, барилгын давхрын тоо, хэмжээнээс хэтрүүлсэн тохиолдолд эскиз зураг батлагдахгүй болно.


Хянасан: Барилга хот байгуулалтын хэлтсийн дарга /Г.Ганзориг/

Боловсруулсан: Хот байгуулалтын архитектор /А.Баттөмөр/

БАРИЛГАЖИХ ТАЛБAYН СХЕМ ЗУРАГ

(Архитектур төлөвлөлтийн давлгаврын хавсралт)

Байршил	Эзэмшигч	Зориулалт
Сүхбаатар дүүргийн 1-р хороо	16 дугаар цэцэрлэг	Хүүхдийн цэцэрлэг



Масштаб 1: 1,000

Тусгаг : WGS 1984 UTM Zone 48N

(Архитектур төлөвлөлтийн давлгаврын хамт хүчинтэй.)

ТАНИХ ТЭМДЭГ

- Одоо байгаа барилга
- Төлөвлөж байгаа барилга
- Газрын хэмжээ
- Цэвэр усны шугам
- Бохирын шугам
- Дулааны шугам
- Холбооны шугам
- Үерийн шугам

ТОДОРХОЙЛОЛТ

1	Төлөвлөж буй байршил
2	Гадаад харилцааны яам
3	Улаанбаатар Сонгодо эмнэлэг
4	Одоо байгаа барилга/16-р цэцэрлэг/

ЭРГЭЛТИЙН ЦЭГҮҮДИЙН СОЛБИЦОЛ

№	X	Y	тал=урт(м)
1	643598.394	5308822.568	1-2=21.00
2	643618.875	5308827.209	2-3=21.00
3	643623.516	5308806.729	3-4=21.00
4	643603.035	5308802.087	4-1=21.00

ОЛГОСОН ТАЛБAYН ТОДОРХОЙЛОЛТ

Эдэлбэр газар (м2)	3508.9
Барилгажих газар(м2)	441.0 м2

БАРИЛГА ХОТ БАЙГУУЛАЛТЫН ХЭЛТЭС

20.6.01/Р САРЫНДНЫ ӨДӨР

ЭСХЭЭ ЗУРАГТЭСЛИЙГ БИРЧИЛХИЙГ ХЭРЭГЛЭГЧ

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
НИЙСЛЭЛИЙН ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГАЗАР
БАРИЛГА ХОТ БАЙГУУЛАЛТЫН ХЭЛТЭС

Нийслэлийн Засаг захиргааны 2-р байр 1101 тоот
Утас: 11-324975, website: <http://mpa.ub.gov.mn>



НУТАГ КОНСАЛТИНГ
ХХКОМПАНИД

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ГАЗАР
УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧИЙН ДҮГНЭЛТ

Нийслэлийн засаг захиргааны III байр,
Ж.Самбуугийн гудамж, 4 дүгээр хороо,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15170
Утас: 7777-5000, Факс: 7777-5120
E-mail: ub_info@inspection.gov.mn
http://www.ub.inspection.gov.mn

2020.07.28 № 02-03-077/1085
танай _____ -ны № _____ -т

**Зураг төсөлд эрүүл ахуйн
хяналт хийсэн тухай**

Танай компаниас ирүүлсэн хүсэлтийн дагуу Монгол Улсын Эрүүл ахуйн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь заалт, Засгийн газрын 2018 оны 97 дугаар тогтоолоор батлагдсан "Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх дүрэм"-ийн 4.1 дэх хэсэг, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын 2017 оны А/164 дүгээр тушаалаар батлагдсан "Барилга байгууламж барих газрын байршил тогтоох, барилгын зураг төсөл зохиох, барилга барих, ашиглалтад оруулах, өргөтгөх, зориулалтыг өөрчлөхөд эрүүл ахуйн хяналт хийж, дүгнэлт гаргах заавар", "Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын барилга, байгууламж, барих газар олголт, зураг төсөл зохиох ашиглалтад хүлээн авахад эрүүл ахуйн хяналт хийж, дүгнэлт гаргах тухай" Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын баталсан 01/57 тоот удирдамж"-ийг үндэслэн 2020 оны 07 дүгээр сарын 28 ны өдөр Эрүүл ахуй халдвар хамгааллын хяналтын улсын ахлах байцаагч О.Алтантуул би Сүхбаатар дүүргийн Засаг даргын тамгын газрын захиалгаар тус дүүргийн 01 дүгээр хороонд баригдах 200 хүүхдийн хүчин чадал бүхий барилгын ажлын зураг төсөлд эрүүл ахуйн хяналт хийлээ.

Зураг төсөл боловсруулсан байгууллагын нэр, зураг төслийн нэр, үе шат:

Ерөнхий төлөвлөгөө, барилга архитектур, барилга бүтээцийн ажлын зургийг Нутаг консалтинг ХХК-д 2020 онд боловсруулж, ерөнхий төлөвлөгөөг 2019 онд Улаанбаатар хотын ерөнхий архитектороор батлуулсан. 2016 оны 04 дүгээр сарын 18 ны өдрийн 2016/10-08 дугаартай архитектор төлөвлөлтийн даалгавартай.

Барилга байгууламж барих газрын зөвшөөрөл:

1/ Нийслэлийн Засаг даргын 2004 оны 01 дугаар сарын 28 ны өдрийн 30 тоот шийдвэртэй. 6002/0102 нэгж талбарын дугаартай. Сүхбаатар дүүргийн 1 дүгээр хорооны нутаг дэвсгэрт цэцэрлэгийн зориулалтаар олгосон 3200.0 м.кв газрыг үндэслэсэн. Барилгажих талбай 441.0 м.кв.

Зураг төслийн товч агуулга:

• 115050014505

Тэнхлэгээрээ 21.0м х 21.0м м-ийн хэмжээтэй, эдэлбэр газартай, зоорийн давхартай. 2 давхар барилга. Барилгын зоорийн давхарт дуу хөгжмийн заал, урлаг заал, гал тогоо, ажилчдын ерөө болон техникийн ерөөнүүдийг, 1 дүгээр давхарт А, Б, В, Г анги болон анги тус бүрд хувцас солих ерөө, аяга таваг хураах ерөө, хөнжил гудас хураах ерөө, ариун цэврийн ерөөнүүд, багш нарын ерөө, эмчийн ерөө, тусгаарлах ерөөнүүдийг, 2 дугаар давхарт А, Б, В, Г бүлгийн 4 анги болон анги тус бүрд хувцас солих ерөө, аяга таваг хураах ерөө, хөнжил гудас хураах ерөө, ариун цэврийн ерөөнүүд, эрхлэгчийн ерөө, архив, бичиг хэргийн ерөө, хурлын ерөө, санхүү, няравын ерөөнүүдийг төлөвлөсөн байна.

Ус хангамж: УСУГ-ын Техникийн нөхцөл олгох комиссын 2019 оны 12 дугаар сарын 25 ны өдрийн 890/19 тоот техникийн нөхцөлтэй. Төвийн цэвэр усны шугамнаас холболттой хэрэглэгчдийн дундын Ф100 мм-ийн шугамын худагнаас холбох, ажлын зургийн явцад зөвшилцөх.

Дулаан хангамж: УБДС ТӨХК-ийн Техникийн нөхцөл олгох комиссын 2020 оны 04 дүгээр сарын 03 ний өдрийн №043/2020 тоот техникийн нөхцөлтэй.

Цахилгаан хангамж: Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ төрийн өмчит хувьцаат компаний 2019 оны 12 дугаар сарын 04 ны өдрийн 15/05815/19 тоот техникийн нөхцөлтэй.

Мэдээлэл холбоо: Мэдээлэл холбоо ХХК-ний 2019 оны 10 дугаар сарын 24 ны өдрийн ТН-В778/2019 тоот техникийн нөхцөлтэй.


Инженер геологийн судалгааны талаар: 2019 онд хийлгэсэн Топ гео техник ХХКомпаний инженер геологийн дүгнэлттэй.

ДҮГНЭХ НЬ:

Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын 2017 оны А/164 дүгээр тушаалаар батлагдсан "Барилга байгууламж барих газрын байршил тогтоох, барилгын зураг төсөл зохиох, барилга барих, ашиглалтад оруулах, өргөтгөх, зориулалтыг өөрчлөхөд эрүүл ахуйн хяналт хийж, дүгнэлт гаргах заавар"-ын 3.1-д заасан баримт бичгийн бүрдэлт болон ажлын зурагт хяналт хийлээ. Хяналтаар зоорийн давхарт төлөвлөсөн цагаан хэрэглэлийн ерөө нь байгалийн гэрэлтүүлэггүй тул 1 давхарт болгож төлөвлүүлэв.

Хяналтаар Сүхбаатар дүүргийн 1 дүгээр хороонд баригдах 16 дугаар цэцэрлэгийн 200 хүүхдийн цэцэрлэгийн барилгын ажлын зураг нь Олон нийт иргэний барилга БНБД 31-03-03 стандарт, Сургалт хүмүүжлийн барилга, байгууламжийн зураг төсөл боловсруулах норм ба дүрэм БНБД 66-88 стандартын шаардлага хангаж байна.

ДҮГНЭЛТ БИЧСЭН :

ЭРҮҮЛ АХУЙ ХАЛДВАР ХАМГААЛЛЫН ХЯНАЛТЫН
УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ  О.АЛТАНТУУЛ



МОНГОЛ УЛС

ГАЗАР ЭЗЭМШИХ ЭРХИЙН ГЭРЧИЛГЭЭ

Дугаар 0002545

16-р цэцэрлэг


(иргэний овог, нэр/хуулийн этгээдийн оноосон нэр)

-Д

Нийслэл аймаг(нийслэл)-ийн Сүхбаатар сум(дүүрэг)-ын
нутаг дэвсгэрт Засаг даргын 20 04 оны 01 дугаар сарын 28 өдрийн
30 тоот шийдвэрийг үндэслэн, нэгж талбарын 6002/0102 дугаар
бүхий 3200 м²/га/ газрыг 15 жилийн хугацаатай
Цэцэрлэг зориулалтаар эзэмшүүлэхээр

энэхүү гэрчилгээг олгов.

Нийслэл аймаг(нийслэл)-ийн
сум (дүүрэг)-ын



ЗАСАГ ДАРГА

М.Энхболд

(гарын үсэг)

(нэр)

8/03

20 04 оны 02 сарын 16

2500
MA

ИРГЭН, ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД ГАЗАР ЭЗЭМШҮҮЛЭХ ГЭРЭЭ

2017 оны 1 сарын 17 өдөр

Улаанбаатар хот

Нэг. Нийтлэг үндэслэл

Монгол Улсын Газрын тухай хууль, Нийслэлийн Засаг даргын 2016 оны 6-р сарын 21-ны өдрийн А/506 тоот шийдвэрийг үндэслэн газар эзэмшүүлэгчийг төлөөлж Нийслэлийн Газрын албаны газрын асуудал эрхэлсэн албан тушаалтан **Батсуурь** овогтой **Батчимэг**, газар эзэмшигчийг төлөөлж **16-р цэцэрлэгийн Эрхлэгч** ажилтай **Дагва** овогтой **Оюунчимэг** нар энэхүү гэрээг байгуулав.

Энэхүү гэрээнд гэрээний салшгүй хэсэг болох дараахь зүйлийг заавал тусгах бөгөөд эдгээрийн бүрдэл дугуу бол гэрээг хүчингүйд тооцох үндэслэл болно. Үүнд:

1. Газрын байршил, хэмжээ, хил хязгаар, заагийг тодорхой харуулсан кадастрын зураг;
2. Газар эзэмшүүлэгчээс газар эзэмшигчид тус газрыг хүлээлгэн өгсөн тухай акт;
3. Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааг Монгол Улсын Засгийн газрын 2003 оны 28 дугаар тогтоолоор баталсан журмын дагуу хийлгүүлж баталгаажуулсан баримт;

Хоёр. Гэрээний нөхцөл

2.1. Газар эзэмшигчид олгосон газрын нийт хэмжээ **3512 /м2/**. Үүнээс:

Нэгж талбарын тодорхой хэсгийг эзэмших зориулалт	Тухайн зориулалтаар эзэмших газрын хэмжээ
---	--

1. Цэцэрлэг	3512 /м2/
--------------------	------------------

2.2. Газрын төлбөрийн хэмжээ

Нэгжийн үнэ **0 төгрөг / тэг төгрөг тэг мөнгө /**

Бүгд үнэ **0 төгрөг / тэг төгрөг тэг мөнгө /**

Үүнээс

1-р улиралд	0	төг	3-р улиралд	0	төг
2-р улиралд	0	төг	4-р улиралд	0	төг

2.3. Газрын төлбөрийг улирал бүрийн эхний сарын 25-ны дотор газар эзэмшүүлэгчийн **Улаанбаатар банкны 2611009722** тоот дансанд шилжүүлж байна.

2.4. Газар эзэмшүүлэх тухай эрх бүхий Засаг даргын шийдвэр гарсан өдрөөр газрын төлбөр хийх хугацааг тооцно.

2.5. Эрх бүхий байгууллагын шийдвэрээр газрын төлбөрийн хэмжээ өөрчлөгдөх тохиолдолд гэрээнд өөрчлөлт оруулна. Ийнхүү газрын төлбөрийг шинэчлэн тогтоолгоогүй бол зохих зардлыг газар эзэмшигч хүлээнэ.

2.6. Газар эзэмшүүлэгчийн тавьсан шаардлагын дагуу газрыг эзэмшинэ.

Гурав. Газар эзэмшүүлэгчийн эрх, үүрэг

3.1. Газар эзэмшигч газрыг гэрээний дагуу эзэмшиж байгаа эсэхийг хянах;

3.2. Уг газрыг эзэмшүүлэхийн зэрэгцээ дараахь шаардлагыг газар эзэмшигчид тавих эрхтэй.

Үүнд:

-Нийтийн эзэмшлийн зам талбайн орц гарцыг чөлөөтэй байлгах;

дагуу хийх;

-Эзэмшилд олгосон газрын хил хязгаарыг газар дээр нь хүлээлгэн өгөх;

-Газрын хэмжээ, зориулалтыг өөрчлөхгүй байх;

-Бусдын газар эзэмшилтэй холбогдсон эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчихгүй байх;

3.3. Газрыг гэрээний нөхцлийн дагуу эзэмшээгүй, энэ талаар болон гэрээний 3.2 дугаар зүйлд тавьсан шаардлагыг биелүүлээгүй буюу Газрын тухай хуулийн 40.1.1- 40.1.6 дугаар зүйлд заасан нөхцөл бий болсон тохиолдолд гэрээг хүчингүй болгож, мөн хуулийн 62 дугаар зүйлд зааснаар хохирлыг нөхөн төлөхийг шаардах;

3.4. Газар эзэмших гэрээг жил бүр дүгнэж, төлбөрийн тооцоо нийлсэн акт үйлдэх;

3.5. Холбогдох хууль тогтоомжоор олгогдсон бусад эрх, үүрэг, хариуцлага хүлээх;

Дөрөв. Газар эзэмшигчийн эрх, үүрэг

4.1. Гэрээний нөхцөлийн дагуу газрыг эзэмших, ашиглах;

4.2. Газрын төлөв байдал, чанарын хянан баталгааг газар өмчлөгчөөс гаргуулж авах;

